



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/57

Улаан-Уул

Тусгай зөвшөөрөл сунгах, сонгон шалгаруулалт явуулах ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.10, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 14/08 дугаар тогтоолоор баталсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам”-ын 1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгжид согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: ИТХ-ын нарийн бичгийн дарга, ГХУСАЗСЗ-ийн нарийн бичгийн дарга / өөртэй нь зөвшилцснөөр/

Гишүүдэд: Өлзийт сум дахь Цагдаагийн хэсгийн төлөөлөгч

Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Хөдөө аж ахуйн тасгийн дарга

6 дугаар багийн Засаг дарга

2. Сумын хэмжээнд согтууруулах ундааны хэрэглээтэй холбогдсон гэмт хэрэг, зөрчил нэмэгдсэн тухай сумын Цагдаагийн хэсгийн тайланг үндэслэн согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй иргэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь журмын 2 дахь шаардлагыг хэрхэн хангаж байгаад хяналт шалгалтын ажлыг холбогдох байгууллага, албан тушаалтантай хамтран хэрэгжүүлж, санал дүгнэлт гарган танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай мэдээллийг иргэд олон нийтэд хүргэж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Баттогтох)-д даалгасугай.

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ



642201093